



**ХХБ-НЫ ПОС ТЕРМИНАЛ
АШИГЛАХ ГАРЫН АВЛАГА**

Verifone V400m

1 АСААХ



ПОС терминалыг асаахдаа ногоон товчийг удаан дарна.

2 УНТРААХ



ПОС терминалыг унтраахдаа улаан товчийг удаан дарж хамгийн доор байрлах **Shutdown** цэсийг сонгоно.

3 ХУДАЛДАН АВАЛТ ХИЙХ

- Худалдан авалтын үнийн дүнг оруулахдаа товчийг дарж дүнгээ оруулан дэлгэц дээрх цэсийг сонгох эсвэл товчийг дарна.
- Тэмдэг гарсны дараа харилцагч картаа дэлгэцэнд ойртуулах, эсвэл картын соронзон тууз болон ЧИП-ээр уншуулна.
- Картын ПИН КОД оруулна.
- Дэлгэц дээр **Амжилттай** хариу өгч баримт хэвлэгдэх ба үүний дараа харилцагчийн хувь хэвлэх бол **ТИЙМ**, хэвлэх шаардлагагүй бол **ҮГҮЙ** гэсэн сонголтыг сонгоно.
- НӨАТ-ын баримт хэвлэдэг тохиргоотой ПОС терминал ашиглаж байгаа тохиолдолд гүйлгээний баримт хэвлэгдсэний дараагаар дэлгэц дээр **НӨАТ-ын баримт хэвлэх үү?** гэж гарах ба НӨАТ-ын системрүү мэдээлэл илгээж баримт хэвлэх бол **ТИЙМ** (Байгууллага болон Хувь хүн), мэдээлэл илгээхгүй буюу НӨАТ-гүй гүйлгээний баримт хэвлэх бол **ҮГҮЙ** гэсэн сонголтыг сонгож баримтыг хэвлэнэ.

4 БУЦААЛТЫН ГҮЙЛГЭЭ ХИЙХ

Буцаалт хийхдээ дэлгэц дээрх цэс рүү орон **1** буюу **Буцаалт** цэсийг сонгоно.

- Нэхэмжлэхийн дугаар** хэсгийг сонгож баримт дээрх INV NUM дугаарыг оруулан дэлгэц дээрх цэсийг сонгох эсвэл товчийг дарж картаа дэлгэцэнд ойртуулах, эсвэл картын соронзон тууз болон ЧИП-ийг уншуулна.
- Сүүлийн гүйлгээ** цэсийг сонгон картаа уншуулж хамгийн сүүлд хийгдсэн гүйлгээг буцаах боломжтой.
- НӨАТ-ын систем рүү илгээгдсэн гүйлгээг буцаахдаа цэс рүү орон **НӨАТ-ийн систем** цэсийг сонгож **Хүчингүй болгох** цэсийг сонгоно.
- НӨАТ хэвлэгдсэн баримт дээрх **ДДТДугаар**-ыг оруулан дэлгэц дээрх цэсийг сонгох эсвэл товчийг дарна.

**Settlement хийсэн тохиолдолд гүйлгээг буцаах боломжгүйг анхаарна уу!
Буцаалтыг зөвхөн тухайн өдөрт хийнэ.*

АШИГЛАХ ЗААВАР



5 НЭГТГЭЛ АВАХ / SETTLEMENT АВАХ

- Settlement авахдаа цэс рүү орон **2** буюу **Нэгтгэл** цэс дээр дарна.
- Settlement-ийн дүн баримтаар хэвлэгдэнэ.

**Settlement нь өмнөх Settlement авснаас хойших гүйлгээний мэдээллийг харуулдаг болохыг анхаарна уу.*

6 ҮЛДЭГДЭЛ ШАЛГАХ

- ХХБ-ны картын үлдэгдэл шалгахдаа цэсийн **4** буюу **Үлдэгдэл шалгах** цэсийг сонгоно.
- Картын ПИН КОД оруулна.
- Картын үлдэгдэл баримтаар хэвлэгдэнэ.


7 БАРИМТ НӨХӨЖ ХЭВЛЭХ

- Баримт нөхөж хэвлэхдээ цэс рүү орон дэлгэц дээрх доош заасан сумыг дарж **1** буюу **Баримт хэвлэх** цэсийг сонгоно.
- 1** буюу **Сүүлийн баримт** цэсээр хамгийн сүүлчийн гүйлгээний баримтыг нөхөж хэвлэнэ.
- 2** буюу **Баримт хэвлэх** цэсээр гүйлгээний баримт нөхөж хэвлэхдээ баримт дээрх INV NUM дугаарыг оруулна.

**Settlement хийсэн тохиолдолд гүйлгээний баримтыг нөхөж хэвлэх боломжгүйг анхаарна уу!*

8 БЭЛЭН ГҮЙЛГЭЭНД НӨАТ ХЭВЛЭХ

- Дэлгэц дээрх цэс рүү орон **3** буюу **НӨАТ-ийн систем** цэсийг сонгоно.
- Баримтыг хэвлэх** хэсгийг сонгож **1** буюу **Бэлнээр** цэсийг сонгох ба мөнгөн дүн оруулж дэлгэц дээрх цэсийг сонгох эсвэл товчийг дарж Хувь иргэн, Байгууллагаар НӨАТ-ийн баримтыг хэвлэнэ.




PAX S900

1 АСААХ/УНТРААХ

- ✗ POS терминалыг асаах болон унтраахдаа улаан товч дээр удаан дарна.

2 ХУДАЛДАН АВАЛТ ХИЙХ

- POS терминалын цаас болон сүлжээ, цэнэг хэвийн байгаа эсэхийг шалгана. 
- Худалдан авалтын үнийн дүнг оруулахдаа  товчийг дарах эсвэл дэлгэц дээр дарна.
- *Худалдан авалтын үнийн дүнг оруулахдаа оронгийн нарийвчлалыг харах. Жишээ: **10000₮** гүйлгээ хийж байгаа үед **10000.00** гэж оруулна!
-  Тэмдэг гарсны дараа харилцагч картаа дэлгэцэнд ойртуулах, эсвэл картын соронзон тууз болон ЧИП-ээр уншуулна.
- Картын ПИН КОД оруулна.
- Дэлгэц дээр **ЗӨВШӨӨРӨГДСӨН** хариу өгч баримт хэвлэгдэнэ.
- Баримт дахин хэвлэж авах бол  товчийг дарна.

*Хэвлэгдсэн баримтын 1 хувийг харилцагчид өгч, хувийг үйлчилгээний байгууллага 90 хоног хадгална.

Картын дугаар	TRADE & DEVELOPMENT BANK MERCHANT NAME GREETINGS	Терминалын дугаар
	TERMINAL ID : 91101234 MERCHANT ID : MERCHANT NAME : CARD TYPE: MC CARDS 0123 45** **** 6789	
Карт эзэмшигчийн нэр	CARDHOLDER	Чекийн дугаар
	PURCHASE EXP. DATE : 07/22 APPROVAL : LRQJV4 BATCH NO : 000020 TRACE NO : 1234 DATE/ TIME : 20. 03. 26 11. 05. 07 RRN : 000775299416 APPLICATION : MASTERCARD AID : A0000000041010 AMOUNT (MNT) 10 ' 000 . 00	
		Үнийн дүн

3 БУЦААЛТЫН ГҮЙЛГЭЭ ХИЙХ

-  Товчийг дарна уу.
-  Товчийг дарна уу.
-  Товчийг дарж буцаах гүйлгээний баримтан дээр хэвлэгдсэн **TRACE NO-ын ард талын 4 оронтой тоог** (Чекийн дугаар) оруулж ногоон товчийг дарна уу.
-  Тэмдэг гарсны дараа харилцагч картаа дэлгэцэнд ойртуулах, эсвэл картын соронзон тууз болон ЧИП-ээр уншуулна.
- Дэлгэц дээрх гүйлгээний дүн баримт дээрх дүнтэй таарч байгаа эсэхийг баталгаажуулна.
-  Товчийг дарахад буцаалтын гүйлгээний баримт хэвлэгдэнэ.

*Settlement хийсэн тохиолдолд гүйлгээг буцаах боломжгүйг анхаарна уу! Буцаалтыг зөвхөн тухайн өдөрт хийнэ.

АШИГЛАХ ЗААВАР



4 НЭГТГЭЛ АВАХ / SETTLEMENT АВАХ

- **Settlement** авахын өмнө **Хураангуй** авч хэвшинэ үү.
-  Товчийг дарж **Reports** ► **1. Хураангуй** цэс дээр дарна уу.

- **Settlement** авахдаа  товчийг дарж **Menu**-рүү нэвтрэн орж **Сервис** цэс дээр дарна уу.
-  **Settlement** товчийг дарна уу.
- **Settlement**-ийн дүн баримтаар хэвлэгдэнэ.

*Settlement нь өмнөх Settlement авснаас хойших гүйлгээний мэдээллийг харуулдаг болохыг анхаарна уу!

5 ҮЛДЭГДЭЛ ШАЛГАХ

-  Товчийг дарна уу.
-  Товчийг дарна уу.
-  Товчийг дарж үлдэгдэл шалгах карт уншуулна.
- Картын ПИН КОД оруулна.
- Картын дансны үлдэгдэл POS-ын дэлгэц дээр гарна.

*Зөвхөн ХХБанкны картын дансны үлдэгдэл шалгах боломжтойг анхаарна уу!

6 БАРИМТ НӨХӨЖ ХЭВЛЭХ

-  Товчийг дарж **Menu**-рүү нэвтрэн **Сүүлийн баримт хуулбар** цэс дээр дарна уу.
-  Товчийг дарна уу.
- Баримт дээр хэвлэгдсэн **TRACE NO-ын ард талын 4 оронтой тоог** (Чекийн дугаар) оруулна уу.
- Хэрэв тухайн гүйлгээний өмнөх баримтыг нөхөж хэвлэх бол чекийн дугаараас 1-ийг хасаж оруулан  товчийг дарна.
- Гүйлгээний баримт нөхөж хэвлэгдэнэ.

*Settlement хийсэн тохиолдолд баримт нөхөж хэвлэх боломжгүй болохыг анхаарна уу!





1 ХУДАЛДАН АВАЛТ ХИЙХ

Соронзон туузтай карт



- Картыг туузаар уншуулна.
- Гүйлгээний дүн оруулна.
- Ногоон товчийг дарна.
- Картын ПИН КОД оруулна.
- Дэлгэц дээр **Зөвшөөрөгдсөн** хариу өгч 1 хувь баримт хэвлэгдэнэ.
- 2 дахь хувь баримтыг хэвлэх бол **5^{JKL}** товчийг дарна.

ЧИП-тэй карт



- Картыг ЧИП-ээр уншуулна.
- Гүйлгээний дүн оруулна.
- Ногоон товчийг дарна.
- Картын ПИН КОД оруулна.
- Дэлгэц дээр **Зөвшөөрөгдсөн** хариу өгч 1 хувь баримт хэвлэгдэнэ.
- 2 дахь хувь баримтыг хэвлэх бол **5^{JKL}** товчийг дарна.

Карт зайнаас уншуулах



- Ногоон товчийг дарна.
- **Contactless Entry** цэсийг дарна.
- Гүйлгээний дүн оруулна.
- Ногоон товч дарна.
- Картын ПИН КОД оруулна.
- Дэлгэц дээр **Зөвшөөрөгдсөн** хариу өгч 1 хувь баримт хэвлэгдэнэ.
- 2 дахь хувь баримтыг хэвлэх бол **5^{JKL}** товчийг дарна.

2 БУЦААЛТЫН ГҮЙЛГЭЭ ХИЙХ

- **2^{ABC}** товчийг дарна.
- Картыг уншуулна. (Зайнаас, ЧИП, Соронзон туузаар)
- Чекийн дугаарыг оруулна. Буцаах гүйлгээний баримт дээрх **TRACE NO-ын ард талын 4 оронтой тоог** оруулж ногоон товч дарна.
- Дэлгэцэн дээрх гүйлгээний дүнг гүйлгээний баримт дээрх дүнтэй таарч байгаа эсэхийг шалгаад ногоон товч дарна.
- Картын ПИН КОД оруулна.
- Дэлгэц дээр **Зөвшөөрөгдсөн** хариу өгч 1 хувь баримт хэвлэгдэнэ.
- 2 дахь хувь баримтыг хэвлэх бол **5^{JKL}** товчийг дарна.

TRADE & DEVELOPMENT BANK
MERCHANT NAME

TERMINAL ID : 91999999
MERCHANT ID : MERCHANT NAME
DATE / TIME : 22.01.01 09.09.59
CARD TYPE: T CHIP

9496 10** **** 0122

CARDHOLDER
PURCHASE

APPROVAL : 3WX67K TRACE NO : 0909
RRN : 001076519641
AMOUNT (MNT)

99 ' 900 . 00

SIGNATURE


PIN VERIFIED

3 ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ ДАХИН ХЭВЛЭХ

- Ногоон товчийг дарна.
- **Сүүлийн баримтын хуулбар** цэсийг сонгоно.
- 1 дугаартай **Сүүлийн баримт** цэсийг сонгож хамгийн сүүлд хийгдсэн гүйлгээний баримт хэвлэнэ.
- Тухайн өдөр хийгдсэн гүйлгээний баримтыг нөхөж хэвлэх бол 2 дугаартай **Баримтын дугаараар** цэсийг сонгож хэвлэх гэж буй гүйлгээний баримт дээрх **TRACE NO-ын ард талын 4 оронтой тоог** оруулж ногоон товч дарна.

4 НЭГТГЭЛ АВАХ / SETTLEMENT АВАХ

- **3^{DEF}** товчийг дарна.
- Нэгтгэл гүйлгээний баримт хэвлэгдэнэ.
- Нэгтгэл гүйлгээг хийсэн тохиолдолд өдөр бүр хийх ба өмнө нэгтгэлийн гүйлгээнээс хойших бүх гүйлгээний мэдээллүүд хэвлэгдэнэ.



1 МЕРЧАНТ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ АНХААРАХ ЗҮЙЛС

-  • ПОС терминалын засвар, үйлчилгээ үзүүлэхээр ирсэн хүний банкны үнэмлэхийг шалгаж баталгаажуулах;
-  • Банкны бичиг баримтгүй хүн ПОС терминалыг солих, програм шинэчлэх, хураан авах гэсэн тохиолдолд татгалзах;
-  • ПОС терминалыг задалж онгойлгох, утас болон бусад нэмэлт төхөөрөмж залгаж буй эсэхийг хянах;
-  • ПОС терминалыг сольсон, өөрчилсөн зэрэг сэжигтэй зүйл илэрсэн тохиолдолд банкинд яаралтай мэдэгдэх;
-  • Нэг хүн **олон төрлийн эсвэл олон тооны картаар** гүйлгээ хийхээр оролдох, картууд нь ажиллахгүй байх, өндөр дүнтэй гүйлгээ уншуулахыг хүсэх, шан харамж амлах, зэрэг **сэжиг бүхий** тэмдэг үйлдэл илэрсэн тохиолдолд банкны **1900-1977** лавлах утсанд холбогдож гүйлгээг шалгуулах, мэдээлэх шаардлагатай.
-  • Мерчант нь ПОС терминалыг хүлээн авсан, засварт өгсөн болон хураалгасан тохиолдолд заавал банкны ажилтантай **хүлээлцэх актыг** заавал үйлдэнэ.

2 МАРГААНТАЙ ГҮЙЛГЭЭ

- Маргаантай гүйлгээ гарсан тохиолдолд **ажлын 30 хоногийн дотор** банканд хандаж дараах сувгуудаар зөвлөгөө мэдээлэл авах, шийдвэрлүүлэх боломжтой.
- **1900-1977** лавлах утсанд хүсэлт гаргах, зөвлөгөө мэдээлэл авах;
- **info@tdbm.mn** и-мэйл хаягт маргаантай гүйлгээний хүсэлтийг баримтын хамт илгээх;
- Өөрт ойрхон банкны салбарт хандан маргаантай гүйлгээний хүсэлтийг баримтын хамт өгч шалгуулна уу.

3 МЕРЧАНТЫН ДАНСНЫ ХУУЛГА ШАЛГАХ

- **www.cardcentre.mn** хаягаар мерчантын дансны хуулгаа харах боломжтой ба уг үйлчилгээнд бүртгүүлэх бол Та өөрт ойр байрлах Худалдаа, хөгжлийн банкны салбарт хандана уу.

**ПОС терминал болон түүний цэнэглэгч залгуур, дагалдах хэрэгсэлд гадны нөлөөтэй аливаа эвдрэл гэмтэл учирсан тохиолдолд хохирлыг мерчант хариуцан барагдуулна.*



Цаас болон засвар үйлчилгээний
дуудлага хүлээн авах утас:

 **1800-1977**